

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИД НЭР ДЭВШИГЧ, АКАДЕМИЧ Д. РЭГДЭЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

ЗАЛГАЖ ХӨГЖИХ ЗАМЫН ЗУРАГЛАЛ

Миний бие 2016 онд “ШИНЖЛЭХ УХААНД АКАДЕМИК ЭРХ ЧӨЛӨӨ, ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИД БИЕ ДААСАН БАЙДАЛ” гэсэн үндсэн үзэл санаанд зангидсан мөрийн хөтөлбөр дэвшүүлэн Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн Ерөнхийлөгчөөр сонгогдсон билээ. Надад итгэн үүрэг хүлээлгэж, хариуцлага ногдуулсан Та бүхнийхээ дэмжлэгийг авч, хичээн зүтгэж ажилласаны үр дүнд дэвшүүлсэн хөтөлбөрөө үндсэндээ бүрэн хэрэгжүүлж чадлаа. Өнгөрсөн 4 жилд Монгол Улсын шинжлэх ухааны салбарт хандлагын өөрчлөлт хийгдэж, ШУА-ийн ажил үйлсэд бодитой ахиц дэвшил гарлаа. ШУА-ийн Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль (2020-2024) зарлагдсаны дараа эхэлсэнээ гүйцээх, бодож төлөвлөснөө үргэлжүүлэх даалгавар өгч, хэд хэдэн хүрээлэнгийн эрдмийн хамт олон миний нэрийг дэвшүүлсэн байна. Эдгээр санал, мөн манай академийн цөөнгүй гишүүний илэрхийлсэн байр суурийг хүндэтгэн үзэж, Монгол Улсын ШУА-ийн дунд хугацааны (2018-2025) стратеги төлөвлөгөөнд тулгуурлан энэхүү мөрийн хөтөлбөрийг боловсрууллаа.

А. Бодлогын залгаас ба мөрийн хөтөлбөрийн зорилго

Үр дүнгийн үнэлгээнээс үүсч буй асуудал

Монгол Улсын шинжлэх ухааны салбарыг ойлгох төр, засгийн хандлага өөрчлөгдөж, шинжлэх ухаанд тулгуурлан улс, орноо хөгжүүлэх нийтлэг хэрэгцээ сэргэж, эрдэм, мэдлэгийг эрхэмлэх олон нийтийн нийгэм-сэтгэл зүйн уур амьсгал бүрдэж, академик эрх чөлөө бодитой хэрэгжих, ШУА байр сууриа бэхжүүлэн хөгжих боломж сайжирч байгаа нь ирээдүйнхээ талаар Та бид хамтаараа бодож шийдвэрлэх тодорхой асуудлуудыг бий болгож байна.

Мөрийн хөтөлбөрийн зорилго

Шинээр бүрдэж буй эрх зүйн орчинд нийцүүлэн үйл ажиллагааны менежментээ сайжруулж, алхам алхамаар нэмэгдэж буй материаллаг бааздаа түшиглэн академичид, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, эрдэм шинжилгээний ажилтаны хүч бололцоог дайчлан, салбарын нөөцүүдээ бататгаж, шинжлэх ухаан, технологи, инновацийн үндэсний чадавхийг бэхжүүлэхэд хүч анхаарлаа төвлөрүүлэх замаар:

а/ Монгол Улсын шинжлэх ухааны мөрийн статустай төв байгууллага- ШУА-ийн шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт болон Монголын нийгэмд эзлэх байр суурийг бэхжүүлэн, улс орны урт хугацааны тогтвортой хөгжилд гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлж, шинжлэх ухааны тодорхой салбаруудаар олон улсын хэмжээнд өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд гол анхаарлаа төвлөрүүлнэ.

б/ Судалгаа, хөгжүүлэлтийн ажлын зорилго, үр өгөөжийг улс орны хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулах талаар бодитой ажил санаачлан хэрэгжүүлнэ.

Б. Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагаа

1. Шинжлэх ухааны Академийн менежментийн чадавхыг бэхжүүлэх

Шинээр бүрдэж буй бодлого, эрх зүйн болон санхүү, хөрөнгө оруулалтын нөхцөл, боломжид түшиглэн хууль санаачлах, хэлэлцэж буй хуулиуд батлагдах үйл явцад хуулийн хүрээнд идэвхтэй оролцох, байгууллагын хэмжээнд удирдлагын оновчтой бүтэц, зохион байгуулалт хийх замаар хэрэгжүүлнэ.

а/ Хууль, бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах, хэлэлцэн батлах, батлагдан гарсан хуульд нийцүүлэн Засгийн газар, яамдаас холбогдох тогтоол, шийдвэр гаргах явцад ШУА-ийн Ерөнхийлөгчийн хувьд аль болох биечлэн оролцохын сацуу ШУА-ийн гишүүд, тэргүүлэгчид, ШУА-ийн Бага чуулганы гишүүд, эрдэмтдийг идэвхтэй оролцуулах ажлыг үр өгөөжтэй зохион байгуулах механизм бий болгох,

б/ ШУА-ийн Их чуулган, Тэргүүлэгчид, Ерөнхийлөгчөөс баталдаг дүрэм, журам, бусад шийдвэрийн төсөл боловсруулах ажилд эрдэм шинжилгээний байгууллага, ажилтнуудын оролцоог хангаж ажиллах,

в/ ШУА-ийн менежментийн чадавхыг сайжруулахад чиглэсэн удирдлагын үр нөлөө бүхий уян хатан тогтолцоо бүрдүүлж төгөлдөржүүлэх асуудлыг тухай бүр цаг алдалгүй шийдвэрлэж байх, хүний нөөц, салбарын удирдлагын чадавхийг бэхжүүлэх

г/ ШУА-ийн Их чуулганаар жилд нэгээс доошгүй, Тэргүүлэгчдийн хурлаар жилд хоёроос доошгүй удаа шинжлэх ухааны тодорхой чиглэлийг дэмжин хөгжүүлэх, улс орны нийгэм, эдийн засгийн бодлоготой уялдуулах болон Засгийн газарт зөвлөх зэрэг асуудлыг хэлэлцүүлдэг болох,

д/ Өнгөрсөн хугацаанд эх суурь нь тавигдсан судалгааны ажлын үндсэн үр дүн, хүний нөөц, санхүү, хөрөнгө оруулалттай зэрэг өгөгдөл бүхий удирдлагын мэдээллийн онлайн системийг хөгжүүлэх, ашиглах,

е/ Мониторинг, үр дүнгийн үнэлгээнд суурилсан цалин, урамшуулалын систем нэвтрүүлэх,

II. Шинжлэх ухаан технологийн тэргүүлэх чиглэлийг шинэчлэн тодорхойлж, судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг нийгэмд түгээн дэлгэрүүлэх

Тэргүүлэх чиглэлийг олон улсын чиг хандлага, улс орны хөгжлийн үе шат, онцлогт нийцүүлэн тогтмол шинэчлэж байх, эрдэм шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн нийгмийн ач холбогдлыг нэмэгдүүлэх ажлыг зохист бүтэц, зохион байгуулалтаар дэмжих, салбар дахь судалгаа, хөгжүүлэлтийн аливаа төслийн сонгон шалгаруулалтыг оновчтой, мэрэгжлийн болгох, хяналт, шинжилгээ, үнэлгээний нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх, улсын захиалга, эрдэм шинжилгээний байгууллагын санаачлагыг зөв хослуулах замаар хэрэгжүүлнэ.

а/ Шинжлэх ухаан, технологи, инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг шинэчлэн тодорхойлж, хүч, хөрөнгийг зөв төвлөрүүлэх талаар санал боловсруулж, Их чуулганаар хэлэлцүүлэн Засгийн газарт өргөн барих,

б/ Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарыг нийтэд нь хамарсан хяналт, шинжилгээ, үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх арга зүй, аргачлал, стандартуудыг бий болгох талаар санал боловсруулан БШУЯ-нд тавих,

в/ “Алсын хараа 2050” урт хугацааны тогтвортой хөгжлийн бодлогын баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр (2020-2024)-ийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн улсын захиалгатай томоохон төсөл санаачлах,

г/ “Шинжлэх ухаан, технологийн мастер төлөвлөгөө (2005-2020)”-ний хэрэгжилтэнд хяналт үнэлгээ хийж, дараагийн шатны үйл ажиллагааны мастер төлөвлөгөө боловсруулах ажлыг санаачлах,

д/ Дотоод хамтын ажиллагааны бодлого, зорилгоо нарийвчлан тодорхойлж, дотоод хамтын ажиллагааны цар хүрээг өргөтгөж, үр ашгийг дээшлүүлэх,

е/ Монгол орны эрдэс баялаг, органик түүхий эдийн нөөцөд түшиглэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд дэвшилтэт технологи бий болгох, нутагшуулах ажлыг холбогдох хүрээлэнгүүдийн үйл ажиллагааны үндсэн чиглэлд тусгуулан хэрэгжүүлэх,

ё/ Математик, тоон технологийн хүрээлэн дээр байгуулж буй тооцоолох төвийг түшиглэн тооцоолол, симуляц ашигласан төслийг нэмэгдүүлж, судалгааны ажлын нийгмийн үр өгөөжийг дээшлүүлэх.

ж/ Эрдэм шинжилгээний сэтгүүлүүдийн чанарыг тогтмол сайжруулж, олон улсад бүртгэлтэй болгох, зэрэглэлийг дээшлүүлэх талаар анхаарч, дотоодоосоо гадаадад нийтлүүлэх чадамж бүрдүүлж эхлэх.

III. Хүний нөөцийг хөгжүүлж, хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх

Шинжлэх ухаан, технологийн салбарт нүүрлээд байгаа хүний нөөцийн хомсдол, тасалдал, үүнээс үүдсэн хязгаарлагдмал байдлаас гарах зорилгоор “Хүний нөөцийн мастер төлөвлөгөө”-г шинэчлэн боловсруулж, эрдэм шинжилгээний ажилтны чадавхыг байнга дээшлүүлэх, тогтвор сууршилтай ажиллах орчин бүрдүүлэх, эрдэм шинжилгээний байгууллага, ажилтны тоог үе шаттай нэмэгдүүлэх арга замаар хэрэгжүүлнэ.

а/ Эрдэм шинжилгээний ажилтны цалингийн сүлжээг шинэчлэх, тоог олшруулах, мэдлэг чадварыг дээшлүүлэх, гадаад хэл, компьютерийн мэдлэгийг сайжруулах байнгын боломжоор хангах цогц арга хэмжээ авах,

б/ “Энтерпренёр судлаач-21” хөтөлбөрийн үр дүндээ тулгуурлан “Энтерпренёр эрдэмтэн” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх,

в/ Шинжлэх ухаан, технологийн салбарын эрдэм шинжилгээний ажилтны залуу халааг байнга бэлтгэх бодлогын хүрээнд ШУА-ийн харьяанд ахисан түвшний сургалтын \магистр, докторын\ их сургууль байгуулах талаар тодорхой санаачлага гаргаж ажиллах,

г/ Олон улсын нэр хүндтэй эрдэм шинжилгээний сэтгүүлд нийтлүүлэх судалгааны өгүүллийн тоог нэмэгдүүлэхэд чиглэсэн урамшуулал бий болгох,

д/ ШУА-ийн Ерөнхийлөгчийн нэрэмжит грант бий болгож, жилд суурь судалгаа болон инновацын чиглэлээр тус бүр нэг эрдэм шинжилгээний залуу ажилтанд олгодог болох,

е/ Хүрээлэнгүүд үйл ажиллагааны болоод менежментийн орлогоосоо чадварлаг залуу докторант нарт грант олгох эрх зүйн орчин бүрдүүлэх,

ё\ Байгууллагын эзэмшил газарт ажиллагсдын орлогод тохирсон 250-аас доошгүй айлын орон сууц бариулах,

ж/ Харьяа эрдэм шинжилгээний байгууллагын суурь судалгаа, судалгаа-хөгжүүлэлтийн ажлын тэргүүлэх чиглэлд нийцүүлэн хүний болон материаллаг нөөцийг харгалзан хүрээлэнгийн дотоод бүтцээ шинэчилдэг болгох,

IV. Судалгаа боловсруулалтын таатай орчин бүрдүүлэн хөгжүүлэх

Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэх, нэгэнт эхэлсэн бүтээн байгуулалтыг төлөвлөсөн хугацаанд нь дуусгах, төр-шинжлэх ухаан-бизнесийн түншлэлийг хөгжүүлэх, мэдээллийн технологийн шинэ ололтыг салбартаа нэвтрүүлэх замаар хэрэгжүүлнэ.

а/ Шинжлэх ухаан, инновацийн төвийн кластерын барилга, байгууламжийн их бүтээн байгуулалтыг хугацаанд нь өндөрлүүлэх чиглэлээр тодорхой удирдамж, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх,

б/ Уг кластерт шаардлагатай багаж техник, тоног төхөөрөмжийн судалгааг 2021 оны эхний хагас жилд багтаан гаргаж, төсөвт суулгах ажлыг зохион байгуулах,

в/ Өртөг, хүчин чадал өндөртэй багаж, тоног төхөөрөмж худалдан авах зардлыг улсын төсөвт 3-4 жилийн өмнөөс төлөвлөн суулгахыг хуульчлан баталгаажуулж, шат шатны төлөвлөгөөнд тусгах талаар санал боловсруулах,

г/ Шинжлэх ухаан, технологийн салбарын багаж, тоног төхөөрөмжийн улсын нэгдсэн тооллого явуулах ажлыг санаачилж, тооллогын дүнд үндэслэн нэн шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийн хэрэгцээг богино, дунд, урт хугацаагаар нарийвчлан гаргаж, улсын төсвийн хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлэх талаар тодорхой санаачлага гаргах,

д/ Мэдээллийн технологийн орчин үеийн дэвшлийг ашиглах шаардлага хангасан дэд бүтцийн сүлжээг хөгжүүлэх,

е/ Хүрээлэн дундын засвар үйлчилгээний цех (workshop) байгуулах,

V. Олон эх үүсвэр бүхий санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх

Улсын төсвийн санхүүжилтийг 4 дахин өсгөх төрийн бодлогод түшиглэн менежментийн орлогыг гадаад, дотоод эх үүсвэрээс тогтмол нэмэгдүүлэх, санхүүгийн үр ашигтай менежмент нэвтрүүлэх, салбарын эмзэг байдлыг бууруулахад чиглэсэн санаачлагыг өрнүүлэх замаар хэрэгжүүлнэ.

а/ Эрдэм шинжилгээний хүрээлэнг үндсэн үйл ажиллагааны санхүүжилттэй болгох, салбарын олон эх үүсвэрт санхүүжилт бий болгох санал боловсруулж шийдвэрлүүлэх,

б/ ШУА-ийн төсвийн боломжийг санхүүжилтийн шинэ эх үүсвэр болгон өргөжүүлэх, төсвийн зарцуулалтыг илүү оновчтой болгох талаар тодорхой санаачлага гарган ажиллах,

в/ Хүрээлэнгүүдийн дотоод, гадаад хамтын ажиллагаа, үндсэн үйл ажиллагааны үр дүнгээр бий болдог орлогыг нэмэгдүүлэх, үр ашигтай зарцуулалтыг дэмжих бүтэц, зохион байгуулалтын механизм бий болгох,

г/ ШУА-ийн төсвийн эрх мэдлийг оновчилж, салбарын бага чуулганууд, харьяа бүтцийн академиудын үйл ажиллагааны зардлыг нэмэгдүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх,

д/ Шинжлэх ухаан, технологийн сангийн үйл ажиллагаа, зохион байгуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн өөрчлөх санал боловсруулж, эрх бүхий байгууллагад тавих,

VI. Инновацийн орчин, соёлыг төлөвшүүлж, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэх

Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого, Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр (2020-2024), Инновацийн тэргүүлэх чиглэл (2020-2025) зэрэг бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангахад салбарын оролцоог нэмэгдүүлэх, нэгэнт эхлүүлсэн оюуны өмч, инновацийн соёл төлөвшүүлэх, судалгааны үр дүнг нийгэм, эдийн засгийн эргэлтэд оруулах тогтолцоо, шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн түншлэлийг хөгжүүлэх чиглэлд олсон ололт амжилтыг бэхжүүлэх, сайжруулах замаар хэрэгжүүлнэ.

а/ ШУА-ийн стратегийн төлөвлөгөөний дагуу шинээр баригдаж буй нэгдсэн цогцолборт инновацийн тогтолцооны гол оролцогч талуудын хамтын ажиллагаанд суурилсан, тэгш оролцоог хангасан инновацийн дэд бүтцийг зохион байгуулж, хөгжүүлэх замаар үндэсний инновацийн зөв тогтолцоог бүрдүүлэхэд хувь нэмэр оруулна,

б/ ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын Инновацийн хэлтэс, хүрээлэнгийн инноваци хариуцсан мэргэжилтнүүд болон эрхзүй, санхүүгийн мэргэшсэн хүний нөөц дээр тулгуурлан Бизнес инкубатор, Хамтын оффис зэргийг байгуулж, гарааны компанийг хөгжүүлэх, инновацийн төсөл хэрэгжүүлэх, технологи нутагшуулах, оюуны өмчийг хамгаалах, инноваци нэвтрүүлэх ажлыг шинэ түвшинд гаргах,

в/ Бизнес инкубатор, хамтын оффис, гарааны компани, технологи дамжуулах төв байгуулж, мэдлэг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг өргөтгөх замаар оюуны өмчийн үнэлэмжийг дээшлүүлэх, түүнийг эдийн засгийн эргэлтэнд оруулах арга замыг боловсронгуй болгох,

г/ ШУТИС, Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр ТӨҮГ-тай хамтран сургалт, судалгаа үйлдвэрлэлийн үндэсний хэмжээний инновацын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж эхлэх.

VII. Гадаад харилцаа, хамтын ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх

Гадаадын адил төстэй байгууллага, их сургуулиуд, эрдэмтдийн багууд, олон улсын болон хоёр талын томоохон хөтөлбөр, санаачлагуудтай нягт хамтран ажиллах замаар салбарын хөгжилд шинэ нөөц, боломж бүрдүүлж, судалгааны өгөөжийг нэмэгдүүлнэ.

а/ Гадаад хамтын ажиллагааг хүний нөөц хөгжүүлэх нэг хөшүүрэг болгон ашиглаж, гадаадад ажиллаж байгаа монгол эрдэмтэд, манай хүрээлэнгүүдийн хооронд холбоо тогтоох, хамтран ажиллах холбоос бий болгох,

б\ Олон улсын байгууллага, гадаад орнуудтай хамтарсан төсөл хэрэгжүүлэх санаачлагыг өрнүүлэн, хүрээлэн, эрдэм шинжилгээний баг, хамтлаг, судлаачдын төсөл бичих, хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлж, төсөл хөтөлбөр санхүүжүүлдэг, хамтран хэрэгжүүлдэг дотоод, гадаадын байгууллага, сангуудтай холбоо тогтооход дэмжлэг үзүүлэх,

в/ Гадаад хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлж эрдэмжүүлэх, эдийн засагжуулах талаар онцгойлон анхаарч ажиллах,

г/ Гадаадтай хамтарсан экспедицүүдийг бодлогоор дэмжихийн тэдгээр дэх манай эрдэмтдийн оролцоог бодлого, хөрөнгө санхүү, хүний нөөц талаас нь нэмэгдүүлэх.

Надад итгэл хүлээлгэж ерөнхийлөгчөөр сонгосон тохиолдолд Засгийн газар, академичид, салбарын нийт эрдмийн хамт олон Та бүхнийхээ дэмжлэгтэйгээр өнгөрсөн хугацаанд бий болгосон ахиц дэвшилээ бататгаж, энэхүү хөтөлбөрт дэвшүүлж буй зорилго, зорилтуудаа бүрэн хэрэгжүүлхийн төлөө чин сэтгэлээсээ хичээн зүтгэж ажиллах болно.

АКАДЕМИЧ ДҮГЭРИЙН РЭГДЭЛ

2020 оны 10 дугаар сарын 14.

Улаанбаатар хот.